# ХАН-УУЛ ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВИЙН МЭДЭЭЛЭЛ ТЕХНОЛОГИЙН АЛБАНЫ 2019 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ТАЙЛАН

2019.12.16

## 1. ВЭБСАЙТ ХӨГЖҮҮЛЭЛТ

Монгол Улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлд “Төр, түүний байгууллагаас хууль ёсоор тусгайлан хамгаалбал зохих нууцад хамаарахгүй асуудлаар мэдээлэл хайх, хүлээн авах эрхтэй” гэж заасан, Төрийн албаны тухай хуулийн мэдээллийн ил тод байдал, мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай, Шилэн дансны тухай хуулиуд мөн Төрийн байгууллагын вэб сайтад тавих шаардлага MNS 6285:2011 стандартаар төрийн байгууллагуудын вэб сайтад тавих шаардлагыг баталсан /Вэб сайтын агуулгын ил тод байдал, вэб сайтын агуулгын ашиглахад хялбар байдал, вэб сайтын агуулгын хэлбэр, ашиглахад хялбар вэб сайт хийх, вэб сайтын ашиглахад хялбар байдлыг шалгах, вэб сайтын агуулгыг батлах болон хянах/, Эрүүл мэндийн сайдын 2013 оны 140 тоот тушаалын хэрэгжилтийг хангаж huemt.ub.gov.mn динамик вэбсайт 2017 оноос хөгжүүлсэн.

Мэдээлэл шуудан харилцаа холбооны газрын даргын 2012 оны 83 тоот тушаалын дагуу домэйн нэрийг дөрөвдүгээр төвшин, хостинг дискийн багтаамжийг 5gb-аар гэрээлэн байршуулсан.

Стандартын үндэсний зөвлөлийн 2017 оны 05 сарын 31 өдрийн 23 дугаар тогтоолоор батлагдсан Төрийн албаны вэбсайтны стандарт MNS 6285:2017 баримт бичигт тусгагдсан өөрчлөлт нь энэ стандартаар төрийн байгууллагуудын вэбсайтад тавих шаардлагыг тогтоосон, энэ стандартын агуулга, шаардлага нь төрийн бус байгууллагад ч нийцэх тул ашиглаж болно.

Иймд Хан-Уул эрүүл мэндийн төв болон Өрхийн эрүүл мэндийн төвүүдийн нэгдсэн http://huemt.ub.gov.mn/ вэбсайт шинэчлэх ажлыг 2019 оны 6 сарын 01-ний өдрөөс туршилтанд оруулан ажиллаж эхлээд байна. Мэдээлэл технологийн алба нь вэбсайтуудыг өөрөө хөгжүүлэлт хийсэн учир байгууллагаас зардал гараагүй болно. Вэбсайт хөгжүүлэх зах зээлийн үнэ судалгаа 3000000 төгрөг байдаг.

Дараах зурагт өөрчлөлт, шинэчлэлүүдийг харууллаа.

- 2016 оны вэбсайт Зураг 1
- Шинэчлэл хийх загвар дизайн зураг 2
- 2017 - 2018 оны нэмэлт өөрчлөлт зураг 3
- 2019 оны туршилт зураг 4



Зураг 1



Зураг 2



Зураг 3




Зураг 4

Мэдээний тоог нийслэлийн дундаж үзүүлэлтээс нэмэгдүүлэх /нэг жилээр 150 мэдээ/ өссөн дүнгээр харуулав. 2019 оны 11 сарын байдлаар

- 2019 онд 1267
- 2018 онд 1116
- 2017 онд 825
- 2016 онд 731

Хандалтын тоолуур нийт 52825 хандалт авсан.

- 2019 он – 12440 хэрэглэгч
- 2018 он – 8242 хэрэглэгч
- 2017 он – 7768 хэрэглэгч
- 2016 он – 7376 хэрэглэгч

## 2. СҮЛЖЭЭНИЙ ДЭД БҮТЭЦ

Хан-Уул эрүүл мэндийн төвийн үйл ажиллагааг цахимжуулах, доголдолгүй явуулах үүднээс Нийслэлийн эрүүл мэндийн газрын даргын 2017 оны 10 дугаар сарын 09 өдрийн 2/1022 тоот тушаалын хүрээнд нийслэлийн нэгдсэн сүлжээнд холбогдсон анхны Эрүүл мэндийн төв, Өрхийн эрүүл мэндийн төвүүд болсон. Сервер компьютерт дотоод сүлжээгээр хандалт хийж эхэлсэн. Иймээс өрхийн эрүүл мэндийн төвүүдийн хэрэглэгчийн компьютерт VPN холболт хийгдэж байсныг зогсоон шилэн кабелийн оптик сүлжээ зохион байгуулснаар гадаад сүлжээнээс халдах халдалтуудыг хязгаарлаж чадсан.

- Эрүүл мэндийн төвөөс Хан-Уул дүүрэг хүртэлх 500м, ХУД 10, 11, 12, 13-р хорооны Өрхийн эрүүл мэндийн төвүүдэд тус бүр 300 м шилэн кабелиудыг Gmobil компаниар татуулсан. Шилэн кабель, Ftp, convertor төхөөрөмжүүдийн өртөг 3800000 төгрөгийн бараа материалыг үнэ төлбөргүй шийдвэрлүүлсэн.




3. СЕРВЕРИЙН ӨРӨӨ

Байгууллагын нэгдсэн сервер байрших өрөөний нөхцөл стандарт шаардлага хангахгүй байсан тул нүүлгэн шилжүүлэх зөвлөмжийг сервер нийлүүлэгч Huawei, Метронетворк ХХК-аас гаргасан байдаг. Серверийн өрөөний ерөнхий нөхцөл, үүсэн нөхцөл байдлыг байгууллагын удирдлагад танилцуулсан бөгөөд 2018 оны 5 сарын 15 байгууллагын удирдлагын шуурхай хурлын шийдвэрийн хүрээнд Серверийн өрөөг 4 давхарт шилжүүлэх ажлыг эхлүүлсэн.

Тус үйл ажиллагааны хүрээнд сервер байршуулах өрөөг засварлан, найдвартай цахилгааны их үүсгэвэр холбох ажлыг Аж ахуйн алба гүйцэтгэсэн.

Мэдээлэл технологийн албаны ажлын хэсэг Rack хайрцаг задлах, угсрах, тог баригч 50 кг 4ширхэг UPS төхөөрөмжийг зөөвөрлөж 380 цахилгааны эх үүсгүүрт холбох, дата сервер, програмын сервер, факс сервер шилжүүлэн байршуулж Автоматжуулах, Тестлэх үйлдлийг зэрэг 8 цагийн үйлчилгээг өөрсдийн нөөц боломцоонд тулгуурлан хийсэн. Байгууллагын дотоод сүлжээ, Ehealth програм хангамжид доголдол үүсгэлгүй уг ажлыг гүйцэтгэсэн.

Серверийн зураг хавсаргав:

- Зураг 1 өмнөх серверийн өрөөнд байршиж байсан сервер. Серверийн нүүлгэх болсон шалтгаан бол 2 давхрын 00 -ын өрөөний доор байршиж байсан учир 00 бөглөрч ус алддаг байсан. Мөн хулдаасаар бүтээсэн байсан нь чийг цохих аюултай.
- Зураг 2 Стандартын дагуу сүлжээний утас болон бусад дагалдах хэрэгслийг байршуулсан өнөөгийн нөхцөл байдал.



Зураг 1



Зураг 2




*Мэдээлэл технологийн шинэчлэл бичиг баримтад Сервеарийн өрөөний бүдээвч зураг 2019 онд шинээр боловсруулсан.*

4. НЭГДСЭН ШИЛЭН КАБЕЛИЙН ИНТЕРНЕТ

Төв салбар, яармаг салбар амбулатори, 16-н өрхийн эрүүл мэндийн төвүүд өөр өөр өндөр үнэтэй интернет авч байсныг зогсоон нэгдсэн интернетийн үйлчилгээг бий болгон интернет үйлчилгээ үзүүлэгч байгууллагаас /ISP/ интернет авч, ISP байгууллагын зүгээс зарим сүлжээний холболтыг NAT сүлжээний төрлөөр зохион байгуулж, гадаад сүлжээний аюулгүй байдлыг хариуцан ажиллахаар гэрээлсэн. Интернет үйлчилгээ үзүүлэгч байгууллагын зүгээс эрсдэлийн нөхцөлийг арилгах зорилгоор байгууллагын сүлжээний замчлагч төхөөрөмжийг шинээр суурьлуулан 2019 оны 01 дүгээр сарын 04-ны өдөр хамгаалалтын тохиргоо хийсэн.

Эрүүл мэндийн сайдын 2013 оны 140 тоот тушаалын хэрэгжилтийг хангаж Төв амбулатори, яармаг салбар амбулаториудыг шилэн кабелийн оптик холболт үүсгэн gmobile өндөр хурдны интернетийг нэвтрүүлсэн. Өмнө өөр интернетийн урсгал тус бүр 8 mbps, 4 mbps нийт 12mbps 680 000 төгрөгөөр авч байсан урсгалыг нэгтгэн **24mbps** болгон тухайн өртгөөр, өрхийн эрүүл мэндийн төвүүдийг тус бүрт 2 mbps 54000 төгрөгөөр 50% хөнгөлттэй үнээр тохирч гэрээлэн ашиглаж байна.

- Хар converter төхөөрөмжөөр байгуулагын интернет гарц
- Саарал converter төхөөрөмжөөр өрхийн эрүүл мэндийн төвүүдийн интернет гарц




5. ДОТООД СҮЛЖЭЭ

Мэдээлэл технологийн албаны 2018 оны ажлын төлөвлөгөөнд байгууллагын дотоод сүлжээг шинэчлэн зохион байгуулахаар тусган төв салбар, яармаг салбар амбулаториудын дотоод сүлжээг босоо, хөндлөн сувагчлал шинээр үүсгэн 2018-аас 2019 оны 1 дүгээр улиралд багтаан хийж гүйцэтгэв. Мөн 16 өрхийн эрүүл мэндийн төвийн дотоод сүлжээг шинчлэн зохион байгуулаад байна.

- Байгууллагын дотоод сүлжээг Дотоод сүлжээний компаниар хийлгэх судалгаа гаргасан боловч төсөвт өртөг 20000000 төгрөгийн саналууд ирүүлсэн тул байгууллагын тухайн жилийн төсөвт суугдаагүй тул хэрэгжүүлэх боломжгүй байсан.

- Иймд мэдээлэл технологийн алба өөрийн нөөц бололцоог гарган Дотоод сүлжээ шинээр хийж эхэлсэн бөгөөд 6600 м 22 хайрцаг UTP кабель орох ба хайрцаг утасны зах зээлийн үнэ 240000 нийт 5280000 төгрөг. Уг төсөв байгууллагын төсөвт тусгагдаагүй тул Мэдээлэл технологийн албанаас Дотоод сүлжээний шинэчлэх ажлыг эхлүүлж, UTP cate 6 кабелуудыг ивээн тэтгэгч байгууллагуудаас гаргуулан, хуучин утсыг ашиглан шинэ сувагчлалыг үүсгэсэн.

- Дотоод сүлжээний хөндлөн сувагчлал гаргахад 32 см хана 127, босоо сувагчлал гаргахад 64 см хана 18 удаагийн цооллого хийж 6600 м UTP кабелыг татаж дотоод сүлжээг бүрэн шинэчилж чадсан.

- Хан-Уул эрүүл мэндийн төвийн дотоод сүлжээний топологи зураг. /Хавсралт 1/




Шинэ топологи




Хуучин топологи

6. ДАТА ХАДГАЛАХ

Мэдээллийн аюулгүй байдлыг хүрээнд Сервер компьютеруудын нууц үгийг долоо хоног бүрийн 5 дах өдөр шинэчилж хэвшсэн талаар Эрүүл мэндийн яамны 2018 оны 12 дугаар сарын 19-ны өдрийн 5/5132 тоот албан даалгаварын хэрэгжилтийн мэдээлэх хуудсанд мэдээлдэг. Эрүүл мэндийн яамны 2018 оны 09 дүгаар сарын 17 өдрийн 3-1/3726 тоот тушаалын хэрэгжилтийн хүрээнд Сервер компьютеруудын gateway, DNS хаягуудаар хязгаарлалт хийн интернет орчноос тусгаарласан.





7. ҮЙЛДЛИЙН СИСТЕМ

Windows 8 - Windows 10...

Хан-Уул дүүргийн эрүүл мэндийн төвийн үндсэн хөрөнгөд 132 ширхэг компьютер бүртгэлтэй байдаг.

2015 оноос хэрэгжиж буй цахим эрүүл мэнд төслөөр 74 шинэ компьютер ирсэн бөгөөд тус компьютерууд нь Windows 8 үйлдлийн системтэй, интерфейсийг хэрэглэхэд хялбар болгохын тулд Windows 10 theme суулгасан байсан тул гацдаг, их ачааллаж CPU, RAM, HDD диск тогтмол 40% хүрч халдаг нь үзүүлтүүдээс харагддаг.

Мөн тус компьютерууд нь системийн BIOS тохиргоотой, үйлдлийн системийн recovery буюу буцаах үйлдэлтэй тул хардыг бүтэн формат хийх зайлшгүй шаардлага тулгардаг. 74 компьютерт үйлдлийн систем солих ажлыг үйлчилгээнд доголдол үйсгэлгүй гүйцэтгэж Windows 10 үйлдлийн системийг суулгаж дууслаа.

2018, 2019 онд давхардсан тоогоор 187 үйлдлийн системийн засвар дуудлагыг шийдвэрлээд байна.





8. РЕНТГЕН ЗУРАГ ФАКС СЕРВЕР

Рентген аппараны компьютерийн хард диск 500gb бөгөөд 140gb систем ажиллаж 350gb зайнд зураг хадгалдаг. Рентген зураг дүүрч рентген аппарат ажиллахгүй болдог тул temp, дата бааз устгах үйлдэл хийж хэвийн үйл ажиллагаанд оруулլаа.




9. ЛАБОРАТОРИЙН ТӨХӨӨРӨМЖ ХОЛБОЛТ

Лаборатори, бактерлогийн төхөөрөмжүүдийг Ehealth програмд холбосон анхны дүүрэг болохоор ажилж байна. Цахим эрүүл мэнд төслөөр хэрэгжиж буй Ehealth програм хангамж нь өмнө хэрэгжиж байгаагүй цогц програм төдийгүй, динамик үйл ажиллагаатай програм хангамж юм. Иймээс төхөөрөмжүүдийг холбоход Метронет config буюу код файлыг шинээр зохиож холболтыг хийдэг.

1. Аувтолазер
2. Respons 920
3. Sysmex
4. Mindray
5. Maglumi 800
6. Vitek 2 compact холбож Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газраас шинжилгээний төлбөрийг нэхэмжлэхээр ажиллаж байна.




10. ZEBRA ЗАСВАР

Дотоод шүүрлийн өрөөнд байрлаж байсан баркод хэвлэгчийн компьютер асахгүй болсон байсныг үйлдлийн систем ахин ачааллаж хэвийн болгосон. Zebra баркод хэвлэгч төхөөрөмж бохирдож, бохирдлын улмаас Calibrate автомат тохируулга алдагдсан байсныг цэвэрлэж CALIBRATE тохируулгыг сэргээж хэвийн ажиллагаанд оруулллаа.

Сувилагчийн пост дээр байрлах Zebra баркод хэвлэгч төхөөрөмж бохирдож, бохирдлын улмаас Calibrate автомат тохируулга алдагдсан байсныг цэвэрлэж CALIBRATE тохируулгыг сэргээж хэвийн ажиллагаанд оруулллаа.




11. ХЯНАЛТЫН КАМЕР

Хяналтын камер аналоги төв салбарт 12, яармаг салбарт 6 ширхэгийг засварлан байршил, харалтын өнцгүүдийг өөрчлөн суурьлуулсан. DVR 16 сувгийн бичигч төхөөрмж 7 хоногийн хугацаатай бичлэг хадгалах боломжтой 2 ширхэг суурьлуулсан. Төхөөрөмжүүдийг дотоод сүлжээгээр дамжуулан хяналтын дэлгэцийг эмнэлгийн хамгаалтын ажилтан болон ЭЭОДаргын өрөөнд LCD 42 инч дэлгэцээр хянадаг.

Хяналтын камерын DVR 16 сувгийн бичигч төхөөрөмжийн хард тоосжилтоос болж шатсан тул хяналтын самбарын байрлалыг сольж хөтөч сувилагчийн байрлалд шилжүүлсэн.

- Төв салбар: Давхар бүрт 2, гадна 2 камер, яаралтай хүлээн авах хэсэгт 2 аналоги камер байршуулан ажиллаж байна.
- Яармаг салбарт : Давхар бүрт 2, гадна 2 аналоги камер ажиллаж байна.



12. ЯАРМАГ САЛБАР...

Яармаг салбар амбулаториод гарсан сүлжээ, програм хангамжийн доголдол цаг тухай бүрт 100% барагдуулан ажилласан.

- UTP кабель 230м
- Ком формат 15 ш





## 13. ЦАХИЛГААН ХОЛБООНЫ ТӨХӨӨРӨМЖ

Хан-Уул эрүүл мэндийн төв нь цахилгаан холбоотой гэрээлэн дугааруудыг ашигладаг боловч цахилгаан холбооны 10 парын кроп төхөөрөмж 2 ширхэг байдаг бөгөөд тохиргоог байгууллага өөрөө хариуцаж ажиллуулдаг.




Цахилгаан холбооны төхөөрөмжийн бүдүүвч зураг

| № | Цахилгаан холбооны төв шугам хаяглалт | | Утасны дугаар | Хэрэглэгч |
|---|---|---|---|---|
| 1 | 4 давхар даргын өрөөний үүдэнд босоо шугам | 340 | 342257 | Хүний нөөц |
| 2 | | 342 | 341917 | НЭМО |
| 3 | | 343 | 341190 | Ерөнхий нягтлан |
| 4 | | 345 | 342003 | Хүлээн авах |
| 5 | | 347 | 341996 | Больниц |
| 6 | | 348 | 341979 | ЭЭО |
| 7 | | 349 | 341170 | Дарга |
| 8 | | 311 | 341916 | Статистик |
| 9 | | 312 | 341003 | Цахим бүртгэл |
| 10 | | 313 | 342493 | Жижүүр |
| 11 | | 317 | 345876 | Поликлиник |
| 12 | | 318 | 345903 | Хүүхдийн зөвлөх |
| 13 | Яармаг салбарын эрхлэгч | | 70049311 | |
| 14 | Яармаг салбарын жижүүр | | 70049252 | |
| 15 | Яармаг салбар статистик | | 70049285 | |

## 14. ТОНОГ ТӨХӨӨРӨМЖИЙН БҮРТГЭЛИЙГ ЦАХИМЖУУЛСАН

Эрүүл мэндийн хөгжлийн төвөөс хэрэгжүүлж буй hepsupdate.ontime.mn програм хангамжид мэдээллийн технологийн тоног төхөөрөмжүүдийг анх удаа бүртгэлжүүлсэн.



## 15. ТОГ БАРИГЧ ТӨХӨӨРӨМЖҮҮДИЙН ХЭВИЙН АЖИЛЛАГАА

Цахим эрүүл мэнд төслийн Тог баригч төхөөрөмжүүд хэвийн ажиллагааны тохиргоо алдаглдаж дохио өгдөг. Дохио өгөх нь цэнэг нь суусан гэсэн үг юм. Тэгэхээр дараах зааврааар цэнэг холболт үүсгэн цэнэглэж болно. 74 тог баригч төхөөрөмжийг цэнэглэсэн.


ТОГ БАРИГЧИЙН (UPS) БАТТЕРЭЙГ ПАРАЛЕЛ ХОЛБОЛТООР ЦЭНЭГЛЭХ ЗААВАР

Загвар: ESS-36V12-9*2AHBPVBB;

(1)(2)-Тэжээлийн оролт, (3)-Гал хамгаалагч/бускатель

- ESS-36V12-9*2AHBPVBB UPS нь хамгийн ихдээ 2-ш паралел холболтыг дэмждэг.
- Паралел холболтыг доорх зураг дээр заасны дагуу хийж гүйцэтгэнэ. Үүнд: UPS Battery (1)-нь ажиллаж байгаа буюу цэнэгтэй баттерэй, UPS Battery (2)-нь цэнэглэх баттерэй юм.
- Холболт хийхээс өмнө баттерэйнүүдийн гал хамгаалагчыг салгасан байх ёстой.





## 16. АЛБАН ХААГЧДЫН АНХААРАЛД

Мэдээлэл технологийн албанд бүртгэлтэй байсан хэвлэгч төхөөрмж Каноныг захиргааны зааланд байрлуулан албан хаагчид материалаа хувилах /канондах/ боломж бүрдүүлсэн. Бусад ажилчин албан хаагчдын ажлын бүтээмжид саад учруулахгүйгээр доорх заавриын дагаа хэрэглэж байхыг зөвлөж байна зөвлөмжийг дээр нь байршуулав.


Canon image RUNNER 2420 хэрэглэх заавар

1. Принтерийг ашиглахдаа тогны залгуурыг залгасан эсэхийг шалгах.

2. Принтерийн баруун доод талд байрлах асаах товч ⏻ off | on дарж асах горимд шилжинэ.

3. Принтерийн цаас дууссан үед доод хэсэгт байрлах тагнаас татаж нээнэ. Принтерийн цаас хийх хэсэгт A4, A3 гэх мэт хэвлэлийн сонголтууд байна. Түүнээс хамаарч цаасаа хэрэглэнэ. A4, A3, A2

4. Бичгийн цаасаа байрлуулсаны дараа буцаан сайтар хаах хэрэгтэй. /Дутуу хаагдсан бол хэвлэхгүй/

5. Амралтын горим цуцлах Power гэсэн товчийг дарна.

6. Принтер бүрэн ассанаар тоонуудыг ашиглан хэдэн ширхэг хувилах командыг зааж өгно болно.

7. Хувилах командыг Start гэсэн ногоон товч дарж эхлүүлнэ.

8. Хэрэглэж дууссан бол та Power товчин дээр дарж унтраана уу.

Жич: Уг принтер нь Хан-Уул эрүүл мэндийн төвийн өмч болно. Уг принтерийг дээр дурдсан зааврааас бусад зүйлсийг оролдон, цохиж, таг, хаалт зэрэг бусад зүйлсийг эвдэлсэн тохиолдолд Танаар төлүүлэх хүртэл арга хэмжээ авахыг Анхаарна уу!!!

Зааврын дагуу ажилсанд баярлалаа.

## 17. ДАРААЛЛЫН МАШИН

Дараалльн машиныг 2017 оноос хэвийн үйл ажиллагаан оруулж 2017 оны 781 503 үзлэг, 2018 оны 757 038 үзлэг, 2019 оны 11 сарын байдлаар 819 322 амбулаторийн нарийн мэргэжлийн эмчийн цаг олголтыг оновчтой шийдсэн.






## 18. ГЕНРАТОР ТӨХӨӨРӨМЖ СУДАЛГАА ХИЙСЭН

Хан-Уул дүүргийн нэгдсэн эмнэлэгт суурьлагдсан 220V цахилгаан гаргагч генратор төхөөрөмжтэй танилцлаа.








## 19. ПРОГРАМ ХАНГАМЖУУД

Эрүүл мэндийн төв дээр хэрэгжиж буй програм хангамжууд хяналт, удирдлагыг хэрэгжүүлэн ажиллаж байна.

| № | Програм хангамжийн нэр | Тайлбар |
|---|---|---|
| 1 | Ehealth | Амбулатори, оношлогоо |
| 2 | H-info | Хөнгөвчлөх, эмийн хими, хэвтэн, өдрийн эмчилгээ |
| 3 | Health.gov.mn | В, С, Жор |
| 4 | Mhealth | Цэргийн насны залуучуудыг эрүүлжүүлэх |
| 5 | Fis.flu.mn | Халдварт томуу |
| 6 | Tandalt.ememut.mn | Эх хүүхэд эндэгдэл |
| 7 | EVAR | Халдварт өвчин |
| 8 | Geltel.tandalt.mn | Халдварт бус |
| 9 | Smartcancer Cancer.tandalt.mn | Хавдар судлал |
| 10 | Tubis.mn | Халдварт өвчин |
| 11 | Smr.telemedicine.mn | Зүрх судасны өвчлөл |
| 12 | WHONET програм | Бакторлогийн кабинетад антибиотик мэдрэг чанарыг бүртгэх |

## 20. EHEALTH ПРОГРАМ ХАНГАМЖ

E-Health эмнэлгийн нэгдсэн програм хангамжыг 2016 оноос хойш доголдолгүй ажиллах нөхцөлийг бүрдүүлэн эмч, сувилагч ажилчдын идэвхтэй 295, 146 эрх нээн, програмын эрхийн төвшин 108 байршуулан, ажил үйлчилгээний төрөл 248 үүсгэн төв болон яармаг салбарын 31 кабинет, 16 өрхийн эмч нарт цаг товлох үйлчилгээг тасралтгүй явуулж байна. Мөн хүлээн авах, хэвтэн эмчлүүлэх тасаг бүрэн холбогдсон хэвтүүлэх хүлээлэг, өвчний катр нээх, хэвтэх 23 өрөөний хаяглал, 96 орны мэдээ бүртгэн өвчтний түүх, эм жорийн мэдээлэл, оношлогоо шинжилгээний бааз, статистик мэдээллийн тайлан, даатгалын нэгдсэн сан үүсгэх нөхцөлийг бүрдүүлэн хянан ажилладаг.

Эрүүл мэндийн яам, Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газрын Цахим мэдээллийн хэлтсээс 2018-2019 онуудад удаа дараа Ehealth програм хангамжийн хэрэгжилтийн үйл ажиллагаатай ирж танилцаж сайжруулалтын үйл ажиллагааг манай байгууллагыг түшиглэн хийсэн. /Эрүүл мэндийн даатгалын хур системтэй холбосон, И-баримт холбогдсон/

Ehealth програм хангамжийг Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газрын баазтай холбосон анхны эмнэлэг болов.






## 21. ДОТООД СҮЛЖЭЭНИЙ INBIT MESSENGER ПРОГРАМ

Байгууллагын дотоод мэдээллийн урсгалын хувьд inbit messenger програм хангамжийг үнэгүй лицензтэй ашиглан Хан-Уул эрүүл мэндийн төв дээр 194, Өрхийн эрүүл мэндийн төвүүд дээр 32 хэрэглэгчийн мэдээлэл агуулсан мессенжер, файл дамжуулагч систем үүсгэн дотоод сүлжээгээнд хэрэглэж байна.




## 22. ЦАГ БҮРТГЭЛИЙН СИСТЕМИЙГ ERP СИСТЕМД ХОЛБОСОН

Нийслэлийн мдээлэл технологийн газраас нэвтрүүлж буй Edoc програм хангамжийг 2016 оноос хэрэгжүүлж эхэлсэн бөгөөд Хан-Уул дүүргийн засаг даргын тамгын газрын 2019 оны 02 дугаар сарын 28-ны өдрийн 01/348 тоот бичгээр ERP нэгдсэн системийг хэрэгжүүлэн байгууллага, 4 тасаг, 53 албан тушаал, албан хаагч 240 бүртгэн мэдээллийг баталгаажуулан, тохиргоог хийж байна.

UBR систем дээр байгууллагын бүх ажилтан, албан тушаалыг оруулж, цаг бүтгэлийн програмыг CheckTime For UbErp програмын тохиргоог хийж байгууллагын ажилтан бүрийн цаг ашиглалт дээр хяналт тавих боломж бүрдүүлсэн.






## 23. СОШИАЛ ХУУДАС ШИНЭЭР ХӨГЖҮҮЛЭВ

Хан-Уул эрүүл мэндийн төвийн албан ёсны /facebook page/ сошиал хуудсыг 2017 оны 09 сард анх нээсэн бөгөөд Хан-Уул дүүргийн төрийн байгууллагууд дунд хамгийн өндөр дагагчтай сошиал хуудсын нэг болоод байна.

- Сошиал хуудасны дагагч 10 025
- Нэг пост дундажаар 7 000 хүн хүрдэг
- Хамгийн их хүнд хүрсэн порс 10 717

- 9 725 дагагч 7 000 үзэгчид хүрэх нь зорилтод хэрэглэгчид нэгдсэн байх хамгийн өндөр статистик юм.







## 24. СОШИАЛ ХУУДАСНЫ ЧАТБОТ

Хан-Уул эрүүл мэндийн төв албан ёсны цахим хуудсанд мэссэнжер системийг болох Чатбот аппликейш програм хангамж ашиглан 2018 оноо хөгжүүлсэн.

- 2019 оны хандалт **4714**
- 11 сарын дундаж **286**



25. ИЛ ТОД БАЙДЛЫН САМБАР ХИЙЛГЭСЭН

Хан-Уул эрүүл мэндийн төв НЭЭЛТТЭЙ ИЛ ТОД байдлыг эрхэмлэнэ. Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийн 3.1 болон тус хуулийн 7 зүйлд зааснаар үйл ажиллагааныхаа ил тод байдлыг хангахтай холбогдуулан Ил тод байдлын самбарыг шинэчлээд байна.

Ил тод байдлын самбар






26. ХӨТӨЧ

Эрүүл мэндийн төвөөр үйлчлүүлэгч иргэнд зориулсан хөтөч самбарууд, 49 кабинетийн өрөөний хаяг, эмч нарийн танилцуулллага эхийг бэлтгэн хэвлэж байршуулсан.














27. СУРГАЛТАНД ИДЭВХТЭЙ ОРОЛЦСОН

Эрүүл мэндийн яам, Нийслэлийн эрүүл мэндийн газраас зохион байгуулж буй 5 удаагийн сургалтанд оролцсон.





28. ЧАДАВХЖУУЛАХ СУРГАЛТ

Нийслэлийн эрүүл мэндийн байгууллагуудын мэдээлэл технологийн ажилтны чадавжуулах сургалтанд хамрагдсан. Тус сургалтаар Багахангай Эрүүл мэндийн төвийн сервер компьютерийн угсарч тестлэх, телемедцини холболтыг хийж гүйцэтгэсэн.





29. ОНЦГОЙ БАЙДЛЫН СУРГАЛТЫН БЭЛТГЭЛ

Нийслэлийн гамшгаас хамгаалах иж бүрэн сургуулийг 2019 оны дөрөвдүгээр сарын 24-26-ны өдрүүдэд зохион байгуулсан бөгөөд энэхүү сургууль нь 1990 оноос хойш Улаанбаатар хотын хэмжээнд анх удаа зохион байгуулагдаж байгаа томоохон сургууль гэдгээрээ онцлог юм.

Тус арга хэмжээний Хан-Уул эрүүл мэндийн албаны бэлтгэл ажил, мэдээлэл техологи ажилтан болон команд штабын байранд ажилласан.т





30. АРГА ХЭМЖЭЭ

Хан-Уул дүүрэг, Нийслэлийн эрүүл мэндийн газраас зохион байгуулсан нээлттэй хаалганы өдөрлөг, эрүүл мэндийн сургалт, сурталчилгааны арга хэмжээ бүрийг зурагжуулах ажлыг гүйцэтгэж, хэвлэл мэдээллийн мэдээ бэлтгэдэг.





31. ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ ХУРЛЫН БЭЛТГЭЛ

Хан-Уул эрүүл мэндийн төвийн Чанарын албанаас зохион байгуулдаг 2018, 2019 оны эрдэм шинжилгээний хурлын бэлтгэл ажлыг хангах ажлын хэсэгт орж хүлээсэн үүрэг даалгавараа чанартай гүйцэтгэсэн.






32. ТАНИЛЦУУЛАГА ПРЕСЕНТАЦИ

Байгууллагын үйл ажиллагаатай холбоотой танилцуулга пресентаци ppt бэлтгэн Нийслэлийн эрүүл мэндийн газар, Хан-Уул дүүргийн удирдлагуудад хамт олноо сурталчилан таниулах үйл ажиллагааг хийсэн.

- Үйл ажиллагааны тайлан хагас жил, бүтэн жилийн танилцуулга
- Үр дүнгийн гэрээний танилцуулага






33. БАГ ТАМИРЧИДАА ҮРГЭЛЖ ДЭМЖДЭГ

Хан-Уул дүүрэг, Нийслэлийн эрүүл мэндийн газраас зохион байгуулсан спортын арга хэмжээ бүрт очиж баг тамирчдаа дэмжиж зурагчны үүрэг гүйцэтгэдэг.




34. УТААНЫ ЭСРЭГ

Хан-Уул дүүргийн Шуурхай штабт Хан-Уул эрүүл мэндийн төвөөс анхны хариуцлагатай 24 цагийн хугацаатай жижүүрээр ажилсан. Биднийг ажиллах хугацаанд Хан-Уул дүүрэгт угаар болон түүхий нүүрстэй холбоотой дуудлага гараагүй мөн өөр бусад санал гомдолгүй амар тайван, их хот утаагүй сайхан хоносон юм. Миний бие жижүүр утас хариуцан ажилж, жижүүрийн тэмдэглэл хөтлөн үүрэг даалгавраа амжилттай гүйцэтгэсэн.





35. “ЭКО ДҮҮРЭГ-УТААГҮЙ ОРЧИН” САЙН ҮЙЛСИЙН АЯН

Эрүүл мэндийн төвийн 130 ажилтан 5 хэсэгт хуваагдан ажлаа эхэлсэн бөгөөд шахмал түлшийг 25,15 кг хэмжин шуудайлж, шуудайны амсрыг оёж битүүмжлэн нийт 810 шуудай 20 тонн шахмал түлшийг савлан, нэг бүрчлэн тоолж “Таван толгой түлш” ХХК-ны ажилтанд хүлээлгэн өглөө.

130 ажилтны нэг байж нэг өдрийн турш Улаанбаатар хотынхоо иргэдийн эрүүл мэндийн төлөө ажиллаа.




## 36. ИНФОГРАФИК

Эрүүл мэндийн үндсэн үзүүлэлтүүдээр инфографик тоон мэдээ шинээр хийж хэвшээд байна.





















37. ТАНИЛЦУУЛАГА, МЭНДЧИЛГЭЭ










































38. ХӨЛТЭЙ СТАНД

































39. ТАЙЛАН, ТӨЛӨВЛӨГӨӨ ГАРГАСАН БАЙДАЛ

- Хэвлэл мэдээллийн I улирлын тайлан;
- Мэдээлэл технологийн 2019 хагас жилийн тайлан;
- Байгууллагын үйл ажиллагааны тайлан 2019 оны хагас жил;
- Үр дүнгийн гэрээний тайлан 2019 оны хагас жил;
- Хэвлэл мэдээллийн II улирлын тайлан;
- Байгууллагын даргын 2019 оны Үр дүнгийн гэрээ, төлөвлөгөө;
- Хэвлэл мэдээллийн III улирлын тайлан;
- Нийслэлийн эрүүл мэндийн газар Цахим эрүүл мэнд төслийн тайлан;
- Эрүүл мэндийн яаманд 2019.08.26 Ehealth програмын тайлан;
- Нийслэлийн эрүүл мэндийн газрын даргын 2018 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн 11 тоот албан даалгаврын хүрээнд 3 улирлын тайлан явуусан;
- Нийслэлийн эрүүл мэндийн газрын 2019.06.07 өдрийн 2/505 тоот хариу тайлан;
- Магадлан итгэмжлэл тайлан /5 жилээр магадлан итгэмжлэл авсан/ 2019.03.19;
- Гамшигаас хамгаалах төлөвлөгөө 2019.03.25;
- Эрүүл мэндийн яам цахим эрүүл мэнд төслийн тайлан 2019.03.27;
- Хан-Уул дүүргийн Вэбсайтад байгууллагын үйл ажиллагааны талаар байршуулах 2019.02.28 өдрийн 01/348, 2019.06.27 өдрийн 12/1412, 2019.09.24 өдрийн 04/1833 тоот албан бичгүүдийн хүрээнд мэдээлэл;
- Эрүүл мэндийн яамны 2019.08.02 өдрийн 2/3487 тоотын хариу тайлан;
- Эрүүл мэндийн хөгжлийн төвийн hepsupdate.ontime.mn сайтад байгууллагын мэдээллийн технологийн тоног төхөөрөмжийн судалгааг нэгтгэн гаргаж оруулсан. Нийслэлийн эрүүл мэндийн газарт 2019.06.10-нд нэгдсэн тайлан хүргүүлэв;
- Нийслэлийн эрүүл мэндийн газрын 2019.06.30 өдрийн 2/459 тоот өрхийн эмнэлгийн вэбсайтны судалгаа;
- Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газарт 2019.05.14 өдрийн 08/776 Ehealth програм хангамж дээр аймаг нийслэл, сум дүүргийн нэгдсэн код гаргаж өгсөн;
- Телемедцини байршуулах 3 удаагийн албан бичгийн хариу;
- Бүх нийтээр мод тарих өдрийг тохиолдуулан мод, бут, сөөг тарьсан тайлан Хан-Уул дүүрэгт 2 удаа;
- Бүх нийтийн цэвэрлэгээний тайлан 2 удаа;
- Эрүүл мэндийн сайдын 2018 оны 12 дугаар сарын 19 өдрийн 5/5132 тоот тушаалын 1 хавсралтын хүнээнд 11 тайлан боловсруулж хүргүүлсэн.

40. ЦААШИД ХИЙХЭЭР ТӨЛӨВЛӨЖ БУЙ АЖИЛУУД

- Мэдээллийн аюулгүй байдлыг журам /Эрүүл мэндийн яамнаас шинэчлэн боловсруулсан журамтай нийцүүлэн гаргаж байна/
- Мэдээллийн техологийн шинэчлэл /байгууллагын нууцад хамаарна/

БАЙГУУЛЛАГЫН ТӨСӨВТ ГАРГАСАН ХЭМНЭЛТ

| № | Ажил үйлчилгээ | Зах зээлийн үнэ | Хэмнэсэн төсөв |
|---|---|---|---|
| 1 | Вэбсайт | 3 000 000 | 3 000 000 |
| 2 | Шилэн кабель | 3 800 000 | 3 800 000 |
| 3 | Интернет | 18 528 000 | 37 056 000 |
| 4 | Дотоод сүлжээ | 20 000 000 | 12 000 000 |
| 5 | Сүлжээний утас | 5 280 000 | 5 280 000 |
| Нийт | | | 61 136 000 төг |

# ДҮГНЭЛТ

Хан-Уул эрүүл мэндийн төвийн үйл ажиллагааг цахимжуулах, доголдолгүй явуулах үүднээс Нийслэлийн эрүүл мэндийн газрын даргын 2017 оны 10 дугаар сарын 09 өдрийн 2/1022 тоот тушаалын хүрээнд нийслэлийн нэгдсэн сүлжээнд холбогдсон анхны Эрүүл мэндийн төв, Өрхийн эрүүл мэндийн төвүүд болсон. Сервер компьютерт дотоод сүлжээгээр хандалт хийж эхэлсэн. Иймээс хэрэглэгчийн компьютерт VPN холболт хийгдэж байсныг зогсоон шилэн кабелийн оптик сүлжээ зохион байгуулснаар гадаад сүлжээнээс халдах халдалтуудыг хязгаарлаж чадсан.

Төв салбар, яармаг салбар амбулатори, өрхийн эрүүл мэндийн төвүүд нэгдсэн интернетийн үйлчилгээг бий болгон интернет үйлчилгээ үзүүлэгч байгууллагаас "ISP" интернет авч, ISP байгууллагын зүгээс зарим сүлжээний холболтыг NAT сүлжээний төрлөөр зохион байгуулж, гадаад сүлжээний аюулгүй байдлыг хариуцаж ажиллах нөхцөлийг бүрдүүлсэн. Интернет үйлчилгээ үзүүлэгч байгууллагын зүгээс эрсдэлийн нөхцөлийг арилгах зорилгоор байгууллагын сүлжээний замчлагч төхөөрөмжийг шинээр суурьлуулан 2019 оны 01 дүгээр сарын 04-ны өдөр хамгаалалтын тохиргоо хийлгэсэн.

Цахим эрүүл мэнд төслийн гүйцэтгэгч компаниудын хүсэлтийн хүрээнд байгууллагын серверийн өрөөг стандартын дагуу шинээр тохижуулан 2018 оны 05 сарын 15 өдөр нүүлгэн шилжүүлэв. Байгууллагын дотоод сүлжээ, Ehealth програм хангамжид доголдол үүсгэлгүй уг ажлыг гүйцэтгэсэн.

Сервер компьютеруудын нууц үгийг долоо хоног бүрийн 5 дах өдөр шинэчилж хэвшсэн талаар Эрүүл мэндийн яамны 2018 оны 12 дугаар сарын 19-ны өдрийн 5/5132 тоот албан даалгаварын хэрэгжилтийн мэдээлэх хуудсанд мэдээлдэг. Эрүүл мэндийн яамны 2018 оны 09 дүгаар сарын 17 өдрийн 3-1/3726 тоот тушаалын хэрэгжилтийн хүрээнд Сервер компьютеруудын gateway, DNS хаягуудаар хязгаарлалт хийн интернет орчноос тусгаарласан.

Мэдээлэл технологийн албаны 2018 оны ажлын төлөвлөгөөнд байгууллагын дотоод сүлжээг шинэчлэн зохион байгуулахаар тусган төв салбар, яармаг салбар амбулаториудын дотоод сүлжээг босоо, хөндлөн сувагчлал шинээр үүсгэн 2018-аас 2019 оны 1 дүгээр улиралд багтаан хийж гүйцэтгэв. Мөн 16 өрхийн эрүүл мэндийн төвийн дотоод сүлжээг шинчлэн зохион байгуулаад байна.

Сонгинохайрхан Эрүүл мэндийн төв, Баянгол эрүүл мэндийн төв, Баянзүрх эрүүл мэндийн төвийн Мэдээлэл технологийн албаны мэргэжилтэн нар ажлын байранд ирж туршлага судалсан.

Хан-Уул эрүүл мэндийн төвийн huemt.ub.gov.mn албан ёсны цахим хуудсанд 2018 онд 1116 буюу өмнөх оноос 191 мэдээ нэмэгдсэн бол 2019 онд 1324 өссөн 208 мэдээ, мэдээллээр өссөн.

Цахим хуудсаа сурталчилах зорилгоор сошиал медиа хуудсуудыг түлхүү ажиллуулж эхэлсэн. Байгууллагын албан ёсны цахим хуудас /facebook page/ Хан-Уул эрүүл мэндийн төвийг дагагчийн тоо 10144 /like/ үзүүлттэй байна, хувь хүнд чиглэсэн аккоунт /facebook account/ Хан-Уул эрүүл мэндийн төвийг хөтлөөд 5000 найзтай үйл ажиллагаа тогтмолжсон. Мөн youtube, twitter зэрэг олон нийтийн цахим сувгуудыг "Хан-Уул эрүүл мэндийн төв" нэрийн дор тогтмол ашиглаж анхааруулага, сургалт, зөвлөмж, зөвлөгөө зэргийг нээлттэй нийтлэн байршуулдаг.

Нийслэлийн эрүүл мэндийн газрын даргын албан даалгаврын хүрээнд цахим хуудсаны мэдээ, мэдээллийн эрчимжүүлэх зорилгоор өдөр бүр нийслэлийн эрүүл мэндийн газрын мэдээлийн ажилтны группээс 262 мэдээг хуваалцсан байна.

Эрүүл мэндийн яам, Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газрын Цахим мэдээллийн хэлтсээс удаа дараа Ehealth програм хангамжийг хэрэгжилтийн үйл ажиллагаатай ирж танилцан сайжруулалтын үйл ажиллагааг /Эрүүл мэндийн даатгалын хур системтэй холбосон, И-баримт холбогдсон/ манай байгууллагыг түшиглэн хийсэн.

Цаашид мэдээлэл технологийн шинэ дэвшилтэд технологуудыг нэврүүлэх мэдээллийн аюулгүй байдалд онцгойлон анхаарч ажиллахаар төлөвлөж байна.

ХАН-УУЛ ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВИЙН
МЭДЭЭЛЭЛ ТЕХНОЛОГИЙН АЛБАНЫ ДАРГА
А.АМАРТӨВШИН